

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.06.24-2017.07.25/

### НЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дахин сонгуулийг 2017 оны 07-р сарын 07-ны өдөр зохион байгуулж 1-р багт 916 иргэн буюу 68,87 хувь, 2-р багт 428 иргэн буюу 58,63 хувь, нийт 1344 иргэн хамрагдаж 65,24 хувьтайгаар амжилттай зохион байгуулсан.

Засаг даргын 2017 оны А/72 тоот захирамжаар “Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах” ажлын хэсэг томилогдон өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу албан даалгаврыг малчин, мал бүхий иргэдэд хүргүүлэн ажиллаж байна.

Шивээговь сумын “Нэртийн цагаан өндөр” овоо тахилга буюу “Нэртийн хурд” уяачдын холбооны баяр наадам 2017 оны 07 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж 3 насны морь уралдаж, 32 бөх барилдаж, сур харваачид цэц мэргэнээ сорьлоо.



Сумын төв талбайн засварын ажлыг 1-р багийн иргэн Б.Баятбаярын 135000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр төсвийн байгууллагуудын ажилтан, албан хаагч нар хамтран засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



## **ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ**

2017 оны 7-р сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

<b>№</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Санхүүжилт /мянган.төг/</b>	<b>Зардлын гүйцэтгэл /мянган.төг/</b>
1.	ИТХ	24 785 600	24 207 100
2.	ЗДТГ	158 672 073	156 647 004

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

<b>№</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Санхүүжилт /төгрөгөөр/</b>	<b>Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/</b>
1.	Эрүүл мэндийн төв	172 902 200	170 731 540.
2.	Соёлын төв	31 669 500	26 758 426
3.	3-р сургууль	520 247 800	513 948 920
4.	3-р цэцэрлэг	233 090 100	178 408 525

## **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

2017 оны эхний хагас жилийн байдлаар Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 30 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 377 нийт 407 өргөдөл хүлээн авч хугацаанд нь 100% шийдвэрлэн ажилласан.

Аймгийн Дотоод аудит, хяналт шинэжилгээ үнэлгээнээс зохион байгуулсан хяналт шалгалтанын бэлтгэл ажлыг хангаж шалгалтанд хамрагдсан.

ЗДТГ-ын ажилтан, албан хаагчидын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээний хагас жилийн хэрэгжилтийг дүгнэсэн.

## **3-Р ЦЭЦЭРЛЭГ**

Цэцэрлэгийн гадаа талбайд чацаргана, үхрийн нүд, мандлын цэцэг, зүлэг, хүлэмжинд хүнсний ногоо тариалж манаач жижүүрүүд тогтмол усалгаа арчилгаа хийж байна.



Цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахаар 11 ажил төлөвлөснөөс 8 ажил хийгдэж төлөвлөгөөний биелэлт 72,7%-тай байна.



### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

Эрүүл мэндийн төвд 54 өвчтөн хэвтэж үүнээс хүүхэд-15, дотор- 38, халдварт- 1 хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

1. Урьдчилан сэргийлэх үзлэг – 18
2. Дуудлага-365
3. Амбулаторийн үзлэгт-185 иргэн хамрагдсан áàéí à.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахаар 4 ажил төлөвлөснөөс 3 ажил хийгдэж төлөвлөгөөний биелэлт 75%-тай байна.

### **УЛСЫН БҮРТГЭЛ**

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 68 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 12 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2017 оны 7 сарын 24-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 10 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн 71 гэрчилгээг эздэд нь олгоод байна.

Иргэдээс энэ сард 52 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

### ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2017 ОНЫ 07 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	45				45	26	19
Төрсөн эх	2	45				45	-	45
Бүртгүүлсэн гэр бүл	3	6				6	6	6
Нас баралт	4	11				11	7	4
Цуцалсан гэр бүл	5	2				2	2	2
Үрчлэгдсэн хүүхэд	6	0				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	64				64	32	32
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	56				56	26	30

### ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2017.07.24.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2017 оны 7-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоолт	2500	5	12500				
2	Иргэний үнэмлэхний үнэ	15000	23	345000	3300	23	75900	
ДҮН		357500			75900			

### НИЙГМИЙН ХАЛАМЖ


Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж асаргааны мөнгөн тэтгэмжид-2 иргэн, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид – 2 иргэнийг хамруулсан.

Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 8 өрхийн 6, 7-р сарын 949000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан олгосон.



## **БАЙГАЛЬ ОРЧИН**

Цэвэр сайхан орчин аяны хүрээнд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран “Хог хаягдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгуулж 20 иргэн хамрагдсан.



Нийтийн их цэвэрлэгээг 6 дугаар сарын 23-ны өдөр аж ахуйн нэгж байгууллагуудын дунд зохион байгуулж 18 аж ахуй нэгж байгууллагын 67 иргэн хамрагдаж 50 метр доторх газар болон төсвийн байгууллагууд хуваарьт талбайгаа цэвэрлэн 16м<sup>3</sup> хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.



## **МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ**

Сумын Засаг даргын 2017 оны А/38 тоот Захирамжийн дагуу мал эмнэлэгийн ажил үйлчилгээ зохион байгуулж 2017 оны эхний хагас жилийн байдлаар 42 цэгийн 5687 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Үүнд: 24 өрхийн 41 хашаа, хороо, 1 бойны цэг хамрагдсан байна.

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 2017 оны 06 дугаар сараас эхлэн 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 122 өрхийн 28188 толгой хонь, хурга хамрагдсан байна.

“Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлэгт сумын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийг хамруулсан.

## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Илчлэг шивээ ОНӨҮГазарт бага оврын зуух авах, угсарч суурилуулах ажлын гүйцэтгэгчээр “Илчит сансар” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

3-р сургуулийн сантехникийн засварын ажлын гүйцэтгэгчээр 1-р багийн иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Сумын төвийг камержуулах ажлын гүйцэтгэгчээр “Чойрын долгио” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд өвсний агуулахын дээврийн засварын ажлыг шууд худалдан авалтын ажлын хэсэг шалгаруулалт хийж 2-р багийн иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж засварын ажлыг 07-р сарын 18-ны өдөр хүлээн авсан.



Илчлэг шивээ ОНӨҮГазарт Бага оврийн зуух авах, угсарч суурилуулах ажлын гүйцэтгэгчээр Говьсүмбэр аймгийн “Илчит сансар” ХХК шалгарч гэрээ байгуулаад байна.

3, 8-р байранд хэрэглээний халуун усны шугам тавих ажлын гүйцэтгэгчээр сумын иргэдийн “Илч” бүлэг шалгагч гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж байна.



Сумын төвийг камержуулах ажлын гүйцэтгэгчээр Говьсүмбэр аймгийн “Чойрын долгио” ХХК шалгарч гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.





Мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж худалдан авах ажлын шууд худалдан авалтыг “Анар үйлс” ХХК-тай гэрээ байгуулан зургийн аппарат, зөөврийн компьютер, өнгөт принтер, проектер зэрэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авлаа.



3-р сургуулийн сантехникийн засварын ажлын гүйцэтгэгчээр 1-р багийн иргэн Г. Батсайхантай гэрээ байгуулан сантехникийн засварын ажлыг гүйцэтгүүлж байна.



МЭДЭЭ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА